



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 1/87

Мандалговь

“Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ”
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчдын сургалт ба мэдлэг чадвар олгох, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1 дүгээр зүйлийн 1.1, 1.2, 2 дугаар зүйлийн 2.1, 3 дугаар зүйлийн 3.1, Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1 дүгээр зүйлийн 3.2.1.1 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албан хаагчдад “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ” сэдэвт сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 1,980,000 (Нэг сая есөн зуун наян мянга) төгрөгийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Сургалтад идэвхитэй хамрагдаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
5. Сургалтыг чанартай зохион байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж, тайлан, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190275